



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 06 өдөр

Дугаар А/07

Чингис хот

Өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийг
сунгасантай холбогдуулан урьдчилан сэргийлэх
арга хэмжээг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.7, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны "Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай" 238 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын №01 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор аймгийн хэмжээнд Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 06:00 цагаас 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 06:00 цаг хүртэлх сунгасугай.

2. Аймгийн хэмжээнд бүх шатны аж ахуйн нэгж, байгууллага, зах худалдаа үйлчилгээний төвүүдэд Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, иргэдийн байршлыг тогтоох зорилгоор QR код байршуулах ажлыг 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн дотор нэвтрүүлж ажиллахыг хувиараа хөдөлмөр эрхэлж буй иргэд, аж ахуйн нэгж байгууллагын дарга, эрхлэгч, сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Улсын Онцгой комиссын 01 албан даалгаврын хэрэгжилтийг хангуулж, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг нэгтгэн аймгийн шуурхай штабт 7 хоног бүрийн Пүрэв гаригт цахимаар болон албан бичгээр ирүүлэхийг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

4. Шуурхай штаб, хариу арга хэмжээний багт тодотгол хийж, албадын бэлтгэл бэлэн байдлыг хангуулж, хяналтын цэгээр орох гарах хөдөлгөөнд хяналт тавьж, журмын хэрэгжилтийг мөрдөж ажиллахыг Шуурхай штабын дарга /дэд хурандаа Ж.Эрдэнэбат/-д даалгасугай.

5. Хорио цээрийн хязгаарлалтын дэглэм зөрчсөн иргэдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлагыг хүлээлгэх ажлыг зохион байгуулахыг Цагдаагийн газар

231010026

/хурандаа Б.Батсайхан/, Тагнуулын хэлтэс /дэд /хурандаа Н. Алтангэрэл/-т тус тус үүрэг болгосугай.

6. Коронавирусын халдвар /COVID-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд иргэдэд гар ариутгах, маск зүүх зэрэг халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдүүлж, хяналт тавин зөрчигчдөд холбогдох хуулийн дагуу арга хэмжээ тооцож /тусгай зөвшөөрөл цуцлах/ ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/, Эрүүл мэндийн газар /Л.Мэндбаяр/, Онцгой байдлын газар /дэд хурандаа Ж.Эрдэнэбат/, Цагдаагийн газар /хурандаа Б.Батсайхан/, сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

7. Зам, тээврийн хөгжлийн сайд, Хүнс, хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн сайдын хамтарсан 2020 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/225, А/379 тоот Мал, мах өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, өвс тэжээлийг хот хооронд тээвэрлэх ажлыг зохион байгуулах тухай тушаалын хэрэгжилтийг хангуулан ажиллахыг авто тээврийн төв /Б.Ганбат/, Хүнс хөдөө аж ахуйн газар /Ж.Энх-Амгалан/, сумдын Засаг дарга нарт даалгасугай.

8. Улсын Онцгой комиссын шуурхай штаб нь тусгаарлалтаас гарч байгаа болон Коронавируст халдвар /COVID-19/ аваад эдгэрсэн иргэдийг орон нутагт буцааж байгаатай холбогдуулан тээвэрлэлт, ариутгал халдваргүйтгэл, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, халдвар тархаах эрсдэл үүсэж болзошгүй тул хяналт шалгалтыг эрчимжүүлж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар /Б.Сүнгээ/, Эрүүл мэндийн газар /Л.Мэндбаяр/, Онцгой байдлын газар /дэд хурандаа Ж.Эрдэнэбат/, Цагдаагийн газар /хурандаа Б.Батсайхан/, сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

9. Өндөржүүлсэн бэлэн байдлын үед бараа, үйлчилгээний үнийн хөөрөгдөл, зохиомол хомсдол үүсгэхгүй байхыг хувиараа хөдөлмөр эрхэлж буй иргэд, аж ахуйн нэгж байгууллагын дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

10. Шуурхай штабын өдөр тутмын үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор онцгой комиссын гишүүдээр ахлуулсан 24 цагаар үүрэг гүйцэтгэж удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах бүрэлдэхүүнийг томилж, нэрс, хуваарийг хавсралтаар баталсугай.

11. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Ц.Чогсомжав/, Шуурхай штабын дарга /дэд хурандаа Ж.Эрдэнэбат/-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ